

Нэмэгдсэн өртгийн албан татварын шинэчлэлт, хэрэгжилтийн үр нөлөө

Value Added Taxation it's Reform and Effect on Economy

Д. Сувдаа¹, Г. Баялаг², М. Батхуяг³

Хураангуй

Бид энэхүү судалгааны ажлынхаа хүрээнд хөгжингүй орнуудын татварын бодлогын чиг хандлага, сайн туршлагыг судалж, Монгол Улсад 2016 оноос хэрэгжиж эхэлсэн НӨАТ-ын урамшууллын шинэ системийн улсын төсөв, татварын орлогод үзүүлж буй нөлөө, албан бус сектор болон нийт эдийн засаг дахь мөнгөн хөрөнгийн эргэлт, түүний ашиглалт, татвар цуглуулах чадвар, бизнес эрхлэгчид болон иргэдийн худалдан авах чадвар зэрэгт хэрхэн нөлөөлж байгааг судалж үнэлэлт, дүгнэлт өгсөн болно.

Түлхүүр үгс: ДНБ, татварын ачаалал, НӨАТ, НӨАТ-ын урамшууллын систем

Abstract

We examined the tax policy trends and best practices of developed countries and tried to give our conclusion by investigating the impact of the new VAT incentive system, that has been implemented in Mongolia since 2016, on the state budget, tax revenue, cash flow in the economy as a whole and informal sector, as well as the impact of its utilization, tax collection capability, and the purchasing power of businesses and individuals.

Keywords: GDP, Tax burden, VAT, VAT incentives

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, Санхүүгийн тэнхим, Доктор (Ph.D)
E-mail: d.suvdaa@num.edu.mn

² Арвин Эрдэнэ Такс ТМЗ ХХК
E-mail: bayalag1979@gmail.com

³ Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт, Стандарт арга зүйн хороо
E-mail: delguungerel@gmail.com

Удиртгал

Stephanny нар (2016) хөгжингүй орнууд ялангуяа Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (ЭЗХАХБ)-ын гишүүн орнууд татварын шинэчлэлтэй холбоотой Олон улсын хамтын ажиллагааны хөтөлбөрт оролцох, түүнтэй холбоотой арга хэмжээ, хэрэгжилтийн өнөөгийн байдал, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаар судалсан байна. Тухайлбал, 2015 оны сүүлчээр хуралдсан G-20-ийн дээд хэмжээний уулзалтын хүрээнд ЭЗХАХБ-ын Base Erosion and Profit Shifting (BEPS) багц хөтөлбөрийг баталснаар ялангуяа шууд татвар болон Үнэ шилжилтийн асуудалтай холбоотой Үндэстэн Дамнасан Корпораци (ҮДК)-иудын хувьд Нэмэгдсэн ертгийн албан татвар (НӨАТ) болон Бараа, ажил үйлчилгээний татвар (БАҮТ)-ын эдийн засагт үзүүлэх нөлөө, ЕХ-ны гишүүн орнуудын худалдааны гол түнш болох Норвеги, Канад, БНХАУ, ОХУ, Турк, АНУ зэрэг том гүрнүүдтэй мэдээлэл солилцох гэрээ хэлцлүүдийг эхлүүлж энэ асуудлын хүрээнд НӨАТ чухал зохицуулалтын үүрэгтэй болох талаар судалжээ. Мөн ЭЗХАХБ, ОУВС, КРМГ (2020) зэрэг олон улсын санхүү татварын байгууллагуудын сүүлийн үеийн судалгаагаар дижитал эдийн засаг, цахим худалдаа эрчтэй хөгжиж нөгөө талаас дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахалтай холбоотой цахим худалдаа өмнөхөөсөө илүү өргөн дэлгэр болж байгаа учир энэ төрлийн бизнес эрхлэгчид болон тэдгээрийн борлуулалт, орлогод НӨАТ ногдуулж, бүрэн цуглуулах асуудалд цогц арга хэмжээг хэрэгжүүлж чадахгүй байгааг онцолж байна.

Монгол Улсад энэ чиглэлээр сүүлийн жилүүдэд Цогт (2011), Лхагважав (2019) нар татварын орчинг олон улсын

чиг хандлагад нийцүүлэн үр ашигтай системийг нэвтрүүлэх, албан бус секторыг ил болгох, эдийн засагт төрөлжилтийг нэмэгдүүлэх НӨАТ-ын шинэчлэлт чухал болохыг онцолсон байна.

Монгол Улсын эдийн засаг нь байгалийн нөөцөд тулгуурласан бөгөөд түүхий эдийн үнийн хэлбэлзэл, гадаад хүчин зүйлсийн нөлөөнд ихээхэн өртдөг. Манай улсад эдийн засгийн өсөлт 2012 оноос хойш удааширч, өндөр инфляци, гадаадын шууд хөрөнгө оруулалт удаашралтай байсаар байна. Тиймээс татварын бодлогоор жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн хөгжлийг дэмжих нь нэн тэргүүний зорилтын нэг болоод байна.

Мөн манай улсын татварын алба дотооддоо татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээг өргөтгөх, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад илүү анхаарч цахим тайлагнал, татварын цахим үйлчилгээнүүдийн хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх чиглэлээр татварын албаны үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтыг үе шаттайгаар шинэчлэн сайжруулж байна. Эндээс үзвэл Монгол Улсын өнөөгийн татварын бодлого, шинэчлэл нь олон улсын татварын бодлого, шинэчлэлийн чиг хандлагад нийцэж байгаагаас гадна өөрийн улс орны хөгжлийн түвшин, эдийн засгийн бүтэц, онцлогт тохирсон бодлого, арга хэмжээг дэс дараатайгаар авч хэрэгжүүлж байна гэж үзэж болохоор байна. Ялангуяа 2020.01.01-ээс эхлэн хэрэгжсэн татварын шинэчлэлийн хүрээнд татварын хялбаршуулсан горим нэвтрүүлж, татвар төлөгчдийг бичил, жижиг, дунд, том гэж сегментлэн тэдгээрийн онцлогт тохирсон татварын бодлого, стратеги хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн нь энэ удаагийн татварын шинэчлэлийн нэг онцлог байв.

Судалгаа

Татварын харилцааны мөн чанар, үндсэн үүргүүдийг зөв ойлгож, хөгжлийн тухайн үеийн агуулгыг зөв тодорхойлж чадсанаар тухайн шатанд хэрэгжүүлэх татварын үзэл баримтлалыг (концепцийг) зөв боловсруулж, ингэснийхээ үндсэн дээр сая тухайн үед хэрэгжүүлэх татварын зөв бодлогыг хэрэгжүүлэх ёстой (Энхбаатар, 2013).


Монгол Улсын хувьд бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадвар сул, хөрөнгө оруулалт болон татварын орчин таатай бус, албан бус сектор их, татварын орлогын дийлэнх хэсгийг цөөн тооны татвар төлөгч бүрдүүлдэг зэрэг асуудлыг шийдвэрлэх буюу татварын суурийг өргөтгөх, татварын хяналтын үүргийг хэрэгжүүлэхэд НӨАТ хамгийн чухал үүрэгтэй. Учир нь татварын орлогын найдвартай, уян хатан эх үүсвэр болох, татвараас зайлсхийх боломж бага гэсэн НӨАТ-ын давуу талуудыг ашиглах нь тохиромжтой гэж бид үзэж байна. Өөрөөр хэлбэл төсөвт төвлөрөх НӨАТ-ын орлого нь эдийн засгийн бодит өсөлт, бууралттай шууд холбоотой байдаг. Тухайлбал

эдийн засаг сайжирч үйлдвэрлэлийн гарц нэмэгдэхийн хэрээр өрх гэр, бизнес эрхлэгчдийн хэрэглээ өснө. Нийт хэрэглээ өсөхийн хэрээр НӨАТ-ын суурь нэмэгдэж, төсөвт төвлөрүүлэх орлого ч дагаад өсөх боломжтой. Нөгөө талаас эдийн засаг дахь мөнгөн хөрөнгийн урсгал, хөрөнгийн үр өгөөж, ашиглалт, далд эдийн засаг зэрэгт татварын тайлагналаар дамжуулан хяналт тавих бүрэн боломжтой.

МУ-ын хувьд 2012-2019 онуудад дунджаар төсвийн орлогын 83 ба түүнээс дээш хувийг зөвхөн татварын орлогоор бүрдүүлсэн байна. Үүнд дараах 5 төрлийн албан татвар нь нийт татварын орлогын дунджаар 78%-ийг эзэлж байна (Зураг 1).

2012-2019 оны дунджаар татварын орлогын ¼-ийг НӨАТ бүрдүүлсэн. Ихэнхи улс оронд төсвийн орлогыг бүрдүүлэхэд НӨАТ тогтвортой, уян хатан эх үүсвэр болдог гэдгийг бид өмнө дурьдсан. Гэхдээ НӨАТ-ын орлого давамгайлах нь орлого багатай хэсгийн татварын ачааллыг орлого ихтэйгийнхээс илүү хөндөж, орлого хуваарилалтад сөрөг нөлөө үзүүлдэг.

Зураг 1. Татварын орлогын бүтэц хувиар, 2012-2019



Эх сурвалж: www.mof.gov.mn-д үндэслэсэн судлаачдын тооцоолол

Хүснэгт 1. НӨАТ-ын хуулийн өөрчлөлт

№	Өөрчлөлт орсон огноо	Өөрчлөлтийн агуулга
1	1998.01.06	НӨАТ хувь хэмжээ 10%, босго 15 сая болсон.
2	1998.08.28	НӨАТ хувь хэмжээ 13%, босгыг 10 сая болсон.
3	2000.11.17	НӨАТ хувь хэмжээ 15% болсон.
4	2001.06.29	НӨАТ босгыг 10 сая болгон бууруулсан.
5	2006.06.29	НӨАТ хувь хэмжээ 10% болсон.

Эх сурвалж: Баялаг (2013)

НӨАТ-ын тухай хууль нь хэрэгжиж эхэлснээс хойш хамгийн их өөрчлөлт орсон хуулиудын нэг бөгөөд эдгээрийг Хүснэгт 1-т нэгтгэн харуулав.

НӨАТ-ын хувь хэмжээний хувьд 14 жилийн өмнө татварын түвшинг 5 нэгжээр бууруулснаас хойш өөрчлөлт ороогүй. Мөн 1998 онд тогтоосон татварын босго нь мөн ААНБ-ууд жижигрэх нөхцөл бүрдүүлэхэд хүргэсэн гэж үзэж болохоор байна.

Дэлхийн улс орнуудад татварын стандарт хувь хэмжээ харьцангуй тогтворжсон. Мөн нилээд улс орнуудад татварын ялгаатай хувь хэмжээ хэрэглэгдэж байна. Татварын ялгавартай хувь хэмжээ хэрэглэх нь орлогын эрс ялгаатай байдлыг зөөлрүүлэх, орлого хуваарилалтыг зохицуулах зорилготой. Өөрөөр хэлбэл улс орнууд өргөн хэрэглээний бараа үйлчилгээнд бууруулсан доогуур хувь хэмжээ хэрэглэх, орлого ихтэй хэсгийн хэрэглэдэг тансаг

хэрэглээний бүтээгдэхүүн, үйлчилгээнд стандарт хувь хэмжээнээс их хувь хэмжээ хэрэглэх замаар зохицуулалт хийж байна.

НӨАТ-ын хувьд бүртгэл хяналтын тогтолцоог сайжруулахаар цахим төлбөрийн баримт, албан татварын төлбөрийн 20 хүртэл хувийг буцаан авах замаар хуулийн хэрэгжилтэд хяналт тавих боломжийг бий болгох урамшууллын систем, НӨАТ суутган төлөгчийн босгыг 5 дахин нэмэгдүүлсэн зэрэг өөрчлөлтийн үр нөлөөг 2012-2019 оны статистикийн тоон мэдээнд харьцуулалт хийж дараах тооцооллыг хийсэн болно.

НӨАТ-ыг хэрэглээнд ногдуулдаг шууд бус татвар учир түүний өсөлт бууралт нь эдийн засгийн тэлэлт, агшилттай шууд хамааралтай байдаг.

Зураг 2-оос харахад хуулийн шинэчлэлт нь ДНБ болон НӨАТ-ын орлогод эерэг нөлөө

Зураг 2. ДНБ, НӨАТ-ын орлогын өсөлт, хувиар, 2012-2019

Эх сурвалж: www.mof.gov.mn, www.1212.mn-д үндэслэсэн судлаачдын тооцоолол

үзүүлсэн байна. Тухайлбал өөрчлөлтийн өмнө НӨАТ-ын орлогын жилийн дундаж өсөлт -0.22% байсан бол 2016 оноос хойш 24.8% болж өссөн байна.


Татварын системийн чухал үзүүлэлт болох татварын ачаалал нь дэлхийн улс орнуудад ямар байгааг Зураг 3 болон Хүснэгт 2-т үзүүллээ.

Дэлхийн улс орнуудын татварын ачаалал дундаж нь 19.9%; багатай нь Бахрейн, Ливан, Ирак, Сомали, Кувейт зэрэг орнууд

1.1-1.65 хүртэл; ихтэй нь Австри, Итали, Финлянд, Швед, Белги, Дани, Франц 41-46 хувьтай байна.

ДНБ-нд эзлэх татварын орлогын дундаж үзүүлэлт өөрчлөлтийн өмнө 24.2, дараа нь 23.7 болж буурсан байна. НӨАТ-ын ачаалал өөрчлөлтийн дараа 6.5-аас 6 болж буурсан чиг хандлага ажиглагдаж байна (Зураг 4). Эдгээр үзүүлэлт ЭЗХАХБ-ын гишүүн 30 орны 1970-2016 оны дундаж татварын орлогын хувьд 34.2%, НӨАТ нь 6.7% байсан (Acosta-Ormaechea &

Зураг 3. Дэлхийн улс орнуудын татварын ачааллын үзүүлэлт, 2017




Эх сурвалж: www.ourworldindata.org/taxation

Хүснэгт 2. Дэлхийн улс орнуудын татварын ачааллын үзүүлэлт, 2017

Mean	Standard Error	Median	Mode	Standard Deviation	Range	Minimum	Maximum	Count
21.2%	0.7%	19.9%	17.5%	10.2%	45.2%	1.1%	46.2%	190

Эх сурвалж: www.ourworldindata.org-д үндэслэсэн судлаачдын тооцоолол

Зураг 4. Татварын нийт орлого болон НӨАТ-ын ДНБ-нд эзлэх хувь



Эх сурвалж: www.mof.gov.mn, www.1212.mn-д үндэслэсэн судлаачдын тооцоолол

Morozumi, 2019).

2018 оны байдлаар НӨАТ-ын ачаалал Унгар, Шинэ-Зеланд улсуудад 9.8% буюу хамгийн өндөр; Австрали, Швейцарьт 3.3% буюу хамгийн бага, дундаж нь 6.8% байна (Consumption Tax Trends, 2020). Энэхүү үзүүлэлт өсөхийн хэрээр татварын орлого нэмэгдэх эерэг нөлөөтэй боловч эцсийн хэрэглэгчдийн татварын ачаалал өсөх сөрөг нөлөөтэй.

2019 оны байдлаар ААНОАТ-ын төлөгчдийн 1/3 орчим нь НӨАТ суутган төлөгчид байгаа бөгөөд ДНБ-ийн 6.7%-тай (Хүснэгт 3) тэнцэхүйц хэмжээний татварын орлого төвлөрүүлсэн байна. Харин ААНОАТ-ын хувьд 2019 оны байдлаар 153.0 мянга (Зураг 5) орчим бүртгэл бүхий татвар төлөгчөөс идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй гэж тооцсон 61.6 мянга орчим нь 1.6 их наяд төгрөг төсөвт төвлөрүүлсэн нь ДНБ-ийн 4.5 хувьтай тэнцүү байна. Эдгээрээс үзвэл НӨАТ-ын боломжит суурийг өргөжүүлснээр татвар төлөгчдийн

НӨАТ суутган төлөгч харилцагч бага байдаг асуудлыг шийдвэрлэх боломжтой юм. ААНОАТ төлөгчийн тоо сүүлийн үед өссөн боловч тэдгээрт Х тайлан илгээх хувь (2019 онд 61%) сүүлийн жилүүдэд тасралтгүй өсч буй нь НӨАТ суутган төлөгчийн эзлэх хувийг бууруулах нэг хүчин зүйл гэж үзэж байна.

Дотоодын болон импортын бараа үйлчилгээний НӨАТ ба буцаан олголтын байдлыг Зураг 6-д дүрсэлсэн болно.


НӨАТ-ын 65 хүртэл хувийг импортын бараа үйлчилгээний НӨАТ эзэлж байна. Буцаан олголтын дүн 2012 онд 62 тэрбум байсан бол 2019 онд 235 тэрбум болж 4 дахин нэмэгдсэн нь иргэдэд олгох 20%-ийн буцаан олголтын үр нөлөө юм. Гэхдээ урамшууллын системийг нэвтрүүлсэн нь татварын бааз суурийг өргөтгөх, далд эдийн засгийг бууруулахад чухал нөлөөтэй. Тухайлбал, ААНОАТ 2016 оноос хойш тасралтгүйгээр огцом өссөн бөгөөд дундаж нь 33% буюу 253 тэрбум

Хүснэгт 3. Татварын ачаалал болон НӨАТ-ын ДНБ-нд эзлэх хувь

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Татварын ачаалал	25.2	26.5	23.2	22.1	20.7	22.7	25.3	26.2
ДНБ-д НӨАТ-ын эзлэх хувь	7.8	7.5	6.2	4.5	4.8	5.8	6.8	6.7


Эх сурвалж: www.tof.gov.mn, www.1212.mn-д үндэслэсэн судлаачдын тооцоолол

Зураг 5. ААНОАТ болон НӨАТ төлөгчдийн тоо



Эх сурвалж: www.tof.gov.mn, www.1212.mn-д үндэслэсэн судлаачдын тооцоолол

Зураг 6. НӨАТ-ын буцаан олголтын хувь хэмжээ, сая төгрөг



Эх сурвалж: www.mof.gov.mn, www.1212.mn-д үндэслэсэн судлаачдын тооцоолол

төгрөгөөр өссөн байна. Харин мөн оноос өмнө дундаж өсөлт нь 3.2% буюу 14 тэрбум төгрөг байв. Олон улсад НӨАТ-ын хяналтын чиг үүргээр дамжуулан татварын системдээ сайжруулалт хийх механизмыг өргөн ашиглаж байна. Тухайлбал, ОХУ-д татварын албаны хяналт, шинжилгээний ажлын гүйцэтгэлийг сайжруулахын тулд дараах арга хэмжээг хөгжүүлж байна.

1. Улсын төсвөөс хууль бусаар авч буй НӨАТ-ын буцаан авалтын арга зүйг нарийн судалж тодорхойлох.
2. Камержуулсан татварын шалгалтын үр ашгийг боловсронгуй болгох (Ширяева, 2018).

НӨАТ-ын боломжит суурийг үнэлэхэд

буюу үр ашигтай байдлыг тооцоолдог үзүүлэлтийн нэг болох НӨАТ-ын орлогын харьцаа (VRR)-г тооцов (Acosta-Ormaechea & Morozumi, 2019).

$$VRR = \frac{VR}{(FCE - VR) * r}$$

Энд: *VR* - НӨАТ-ын орлого; *FCE* - хэрэглээний нийт зардал; *r* - НӨАТ-ын хувь

Манай улсын хувьд НӨАТ-ын орлогын харьцаа (VRR) нь сүүлийн жилүүдэд хамгийн багадаа 2015 онд 0.67 хүрч байсан бөгөөд сүүлийн 2 жилийн турш өссөн байна.

ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын 2018 оны VRR-ын дундаж нь 0.56; хамгийн бага

Хүснэгт 4. VRR тооцоолол, сая төгрөг

Он	Эцсийн хэрэглээ	НӨАТ-ын орлого	Стандарт хувь хэмжээ	VRR
2012	11,105,416	1,296,451	10%	1.32
2013	13,279,276	1,435,092	10%	1.21
2014	15,480,925	1,371,725	10%	0.97
2015	16,803,285	1,049,589	10%	0.67
2016	16,634,246	1,140,721	10%	0.74
2017	18,472,370	1,618,492	10%	0.96
2018	21,381,021	2,196,413	10%	1.14
2019	24,912,555	2,484,413	10%	1.11

Эх сурвалж: 1212.mn үндэслэсэн судлаачдын тооцоолол

нь Мексик 0.34, Итали, Колумба 0.38; хамгийн өндөр нь Шинэ Зеланд 0.99 байна (Consumption Tax Trend, 2020).

Энэ үзүүлэлтийн болон ДНБ-ийн өсөлтийн хоорондын хамаарлыг тодорхойлохоор шугаман регрессийн шинжилгээ хийхэд дараах үр дүн гарсан болно. Үүнд:

$$GDP = 0.84 + 0.29 * VRR$$

ба тэгшитгэлийн үнэмшил нь $R^2 = 0.79$.

VRR нь нэг нэгжээр нэмэгдэхэд ДНБ 0.29 нэгжээр нэмэгдэхээр байна.

Монгол Улс нь НББОУС-ыг нэвтрүүлээд даруй 30 орчим жилийг өнгөрч байгаа хэдий ч хангалттай хэмжээний үзүүлэлтийг бий болгож чадаагүйг Хүснэгт 5 илтгэж байна.

Мөн 2015.12.31-ний өдрөөрх Эдийн засгийн ил тод байдлын тухай хуулиар 34.7 их наяд төгрөгийн хөрөнгө, орлого ил болсон. Мөн 2015-2016 оны санхүүгийн тайлангийн өрсөлдөх чадварын үзүүлэлтээр 140 орноос 104-т орсон зэрэг нь санхүүгийн тайлангийн мэдээллийн чанар сул, алдаатай болон орхигдуулсан мэдээлэл их байсныг илтгэж байна. Эдгээрт нөлөөлөх голлох хүчин зүйл нь татварын систем юм (Гантулга, 2020).

Харин 2016 оноос шинэчлэн найруулсан НӨАТ-ын тухай хуулийг хэрэгжүүлж, аж ахуйн нэгж хоорондын, аж ахуйн нэгж хувь хүн хоорондын ажил гүйлгээг www.ebarimt.mn цахим бүртгэлийн системд бүртгэх болсон нь нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүртгэлийг болон

түүнд үндэслэдэг орлогын бүртгэл, татвар ногдуулалтыг үндсээр нь сайжруулсан шинэчлэл болж чадсан юм (Лхагважав, 2019).

НӨАТ-ын хуулийн шинэчлэлтийн хамгийн чухал нөлөөг илэрхийлэх санхүүгийн тайлагналын системийн өөрчлөлтийн асуудлыг илэрхийлэх зорилго бүхий анкетын судалгааны үр дүнг нэгтгэсэн байдлаар илэрхийлэв.

- Үйл ажиллагаа явуулж буй хугацааны хувьд 5 дээш жил нь 73% байна. Үүнд 11-ээс дээш жил үйл ажиллагаа явуулж буй ААН 39.5% буюу хамгийн өндөр хувийг эзэлж байна. Эдгээрээс харахад үйл ажиллагаа нь харьцангуй тогтворжсон байгууллагад үүсч буй нөлөөллийг илэрхийлэхээр байна.
- Нийт судалгаанд хамрагдсан ААН-ийг салбараар нь авч үзвэл, 75.5% худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байна.
- Жилийн борлуулалтын орлогын хэмжээний хувьд 31.9% нь 50.0 сая хүртэл орлоготой хялбаршуулсан горимоор тайлагнах ААН, хамгийн их нь 50.0 саяас 3.0 тэрбум хүртэлх нь 50.4% байна. Энэ нь бичил, жижиг, дунд сегментийн хамрах хүрээ голчилсон байна.
- Татварын албаны цахим системд өгсөн үнэлгээг 65.8% нь дунд зэрэг гэсэн байна.
- Татварын албаны ажилчдын ёс зүй, харилцаанд өгсөн үнэлгээ 61.4% нь

Хүснэгт 5. МУ-ын НББОУС-ын нэвтрэлтийн байдал

Он	НББОУС-ын нэвтрэлт		
	Бүрэн	Хагас	Үгүй
2010	48.8%	37.2%	14%
2016	56.5%	34%	9.5%

Эх сурвалж: www.mains.mn

дунд зэрэг гэж үнэлсэн.

- Харилцагч байгууллагын дунд (бэлтгэн нийлүүлэгч) НӨАТ суутган төлөгчдийн эзлэх хувь нь хамгийн өндөр буюу 41-60% байна. Өмнө дурьдсан ААНОАТ-ын 1/3 нь НӨАТ суутган төлөгч байгаа, мөн тус хуулийн чөлөөлөлтийн хүрээнд хамаарч буй салбарын хязгаарлалт зэрэгтэй холбоотой юм.
- Е-баримтын систем нэвтэрснээр байгууллагын төсөвт төлөх НӨАТ-т гарсан өөрчлөлт хэр зэрэг байна гэсэн асуулгад өөрчлөлт ороогүй гэж 43.6% нь хариулсан байна. Багахан хэмжээгээр буурсан гэдэг нь 20.9% байна.
- НӨАТ-тай холбоотой танай байгууллагад учирч буй бэрхшээлтэй асуудал гэсэн асуулгад: НӨАТ суутган төлөгч харилцагч бага гэж 38.4%, НӨАТ-ын хувь хэмжээ өндөр гэж 36.6% тус тус хариулсан байна.
- Е-баримт төлбөрийн систем нэвтэрснээр танай байгууллагад гарсан эерэг өөрчлөлтүүдийн хувьд НББ-ийн анхан шатны баримт бүрдүүлэлтэд дэвшил гарсан гэж 56.3% үзсэн байна.

Эдгээр санал асуулгын үр дүнг нэгтгэн авч үзвэл бизнес эрхлэгч ААН-үүдийн бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч байгууллагууд бүгд НӨАТ суутган төлөгч биш байгаа нь тухайн ААН-ийн НӨАТ төлөлтөд сөрөг нөлөө үзүүлж байна. Иймээс НӨАТ-ын босго оновчтой эсэх, НӨАТ суутган төлөгчөөс чөлөөлөгдөх үйлдвэр, үйлчилгээний хүрээ мөн оновчтой эсэхийг авч үзэх зайлшгүй шаардлага гэдгийг харуулж байна.

Нөгөө талаас НӨАТ-ын урамшууллын систем, е-баримтын систем хэрэгжүүлсэн нь байгууллагын хувьд НББ-ийн анхан

шатны баримт бүрдүүлэлтэд дэвшил гарсан гэж 56.3% нь үзсэн байна. Мөн татварын хувь хэмжээ өндөр байна гэсэн нийтлэг үнэлэлт дүгнэлт өгснийг бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид анхаарах шаардлагатайг тус тус харуулж байна.

Дүгнэлт

Орчин үеийн татварын бодлого, шинэчлэл түүний чиг хандлагыг хөгжингүй болон хөгжиж буй орнуудын сайн туршлагад үндэслэн харьцуулан судалснаар Монгол Улсын татварын бодлогын хэрэгжилт, шинэчлэлийн өнөөгийн байдлыг НӨАТ-ын жишээн дээр үндэслэн судалж үнэлэлт дүгнэлт өгөх, түүнчлэн татварын системд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг олж илрүүлэн татварын бодлогын эрх зүйн шинэчлэлтэй уялдуулж шийдвэрлэх арга замыг тодорхойлох үндсэн зорилго тавьж энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэсэн болно.

Татварын бодлого нь татварын зорилго, зарчим, нөлөөллийн хамгийн зохистой уялдаа харьцааг тухайн улс орны түүхэн тодорхой нөхцөлд тавигдаж байгаа хөгжлийн зорилттой уялдуулах буюу хөгжлийн тухайн шатанд алийг нь илүүтэй тавьж, алийг нь сулруулах нь зохистой байх тухай асуудлыг өөртөө агуулдаг. Өөрөөр хэлбэл төрийн санхүүгийн хэрэгцээ, нийгэмд тулгарсан асуудлуудыг шийдвэрлэх болон эдийн засаг нийгмийн зорилгод хүрэхийн тулд төрийн зүгээс явуулж буй зорилго, чиглэлтэй үйл ажиллагаа юм. Иймд бидний энэхүү судалгааны ажил нь сүүлийн жилүүдэд (2016-2019) Монгол Улсын татварын системд хийгдсэн татварын шинэчлэл тухайлбал, НӨАТ-ын шинэчлэлийн үр нөлөөг тооцоолох, үр ашигтай татварын

систем бүрдүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох, тухайлбал татварын бодлогын хэрэгжилт нөлөөг үнэлэх, цаашид бодлого боловсруулах хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлүүдээр судалгаа хийж, үнэлэлт дүгнэлт өгсөн болно.

Манай улсын татварын системийн үр дүнг илтгэх татварын ачаалал дэлхийн улс орнуудын дундаж түвшинтэй ойролцоо, ихтэй гэсэн ангиллын улс орнуудаас 2 дахин бага байна. НӨАТ нь орлогын найдвартай эх үүсвэр болох боловч эцсийн хэрэглэгч нарт татварын дарамт ирэх, тэр тусмаа орлого багатай хэсэгт илүүтэй хүндрэл үүсгэдэг учир төсвийн орлого бүрдүүлэлтэд зохистой түвшинд байлгахад анхаарах хэрэгтэй.

НӨАТ-ын шинэчлэлт нь татварын суурийг өртгөхөд чухал болохыг түүнтэй нягт уялдаатай ААНОАТ-ын өсөлтөөр илэрхийлэгдэж байна. Нөгөө талаас НББОУС нэвтрэлтийн түвшинг нэмэгдүүлэх, санхүүгийн тайлагналын мэдээллийн үр ашигтай байдлыг сайжруулахад энэ хуулийн зохицуулалтын үр нөлөө маш чухал билээ.

НӨАТ хэрэглээнд ногдуулдаг татвар учир түүний өөрчлөлт нь ДНБ-ийн өсөлт, бууралттай хамааралтай болох нь бидний

хийсэн регрессийн шинжилгээний үр дүнгээс харагдаж байна.

НӨАТ-ын шинэчлэлтийн үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд олон улсын түвшинд анхаарал татаж буй цахим-худалдаанд татвар ногдуулах асуудлыг анхаарч үзэх хэрэгтэй байна.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд ААНБ-ын нягтлан бодогчдоос авсан санал асуулгын үр дүнг нэгтгэн авч үзвэл НӨАТ суутган төлөгч тухайн ААН-ийн хувьд бэлтгэн нийлүүлэгч болон худалдан авагч байгууллагууд нь бүгд НӨАТ суутган төлөгч биш байгаа нь тухайн ААН-ийн НӨАТ төлөлтөд сөрөг нөлөө үзүүлж байна. Иймээс НӨАТ-ын босго оновчтой эсэх, НӨАТ суутган төлөгчөөс чөлөөлөгдөж буй үйлдвэр, үйлчилгээний хүрээ мөн оновчтой эсэхийг цаашид нарийвчлан авч үзэх шаардлагатай гэдгийг харуулж байна.

Нөгөө талаас НӨАТ-ын урамшууллын систем, е-баримтын систем хэрэгжүүлсэн нь тухайн асуулгад оролцсон ААН-ийн 56.3% нь НББ-ийн анхан шатны баримт бүрдүүлэлтэд дэвшил гарсан гэж үзсэн байна. Мөн татварын хувь хэмжээ өндөр байна гэсэн нийтлэг үнэлэлт дүгнэлт өгснийг бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид анхаарах шаардлагатайг харуулж байна.

Ашигласан материал

- Acosta-Ormaechea, S. & Morozumi, A. (2019). *The Value Added Tax and Growth: Design Matters*. Discussion Papers 2019/04, University of Nottingham, Centre for Finance, Credit and Macroeconomics (CFCM).
- Carrol, R., Cline, R., Neubig, T., Diamond, J., & Zodrow, G. (2010). *The Macroeconomic Effects of an Add-on Value Added Tax*. Ernst & Young.
- OECD (2020). *Consumption Tax Trends 2020, VAT/GST and Excise Rates, Trends and Policy Issues*. OECD publishing, Paris.
- Page, A. (2017). *KPMG Survey on VAT/GST and Cross-Border Services*.
- Saaty T. L. (2005). *The Analytic Hierarchy and Analytic Network Processes for the Measurement of Intangible Criteria and for Decision-Making*. In: Multiple Criteria Decision Analysis: State of the Art Surveys. International Series in Operations Research & Management Science, 78. Springer, New York, NY.
- Schenk, A. (1999). Radical Tax Reform for the 21st Century: The Role for a Consumption Tax. *Chapman Law Review*, 2(1), 133-156.
- Баялаг, Г. & Нацагдорж, Д. (2015). *К вопросу о совершенствовании налога на добавленную стоимость*. Москва
- Баялаг, Г. (2013). Монгол Улсын нэмэгдсэн өртгийн албан татварын өнөөгийн төлөв байдалд хийсэн шинжилгээ. *Мэргэшсэн нягтлан бодогч*, 13(1).
- Бизнесийн орчны судалгаа-2017, МУИС-БС, МҮХАҮТ.
- Бизнесийн орчны судалгаа-2020, МУИС-БС, МҮХАҮТ.
- Гантулга, Г. (2020). *Нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо, мэдээллийн чанар*. ММНБИ-ийн МТХ-ийн сургалт.
- Лхагважав, Б. (2019). *Нэмэгдсэн өртгийн албан татварын шинэчлэлд суурилан татварын орлогын бүтцийг оновчлох зарим асуудал*.
- Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, 2012-2019.
- Монгол Улсын нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль.
- Оюунчимэг, Ч. (2008). *Налог на добавленную стоимость в условиях перехода к рыночной экономике*.
- Сувдаа, Д. (2020). *Татварын багц хуулийн шинэчлэлийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийн судалгаа*. ШУТСангийн төсөл, 2018-2019.
- Түмэннамсрай, Э. (2017). *Нэмэгдсэн өртгийн албан татварын эдийн засагт үзүүлэх нөлөөг тооцох нь*.
- Цогт, О. (2011). *Монгол Улсын НӨАТ хуулийн хэрэгжилт цаашдын чиг хандлага*.

Ширяева, Н. М. (2018). Детерминанты совершенствования администрирования налога на добавленную стоимость в российской федерации. *Аудит и Финансовый Анализ*, 1, 12-16.

Энхбаатар, С. (2013). *Татварын тогтолцоог боловсронгуй болгох нь*. Өнөөдөр, 297.

Энхболд, З. (2019). *Нэмэгдсэн өртгийн албан татварын системийг боловсронгуй болгох арга зам*.

www.ourworldindata.org

www.oecd.org/tax/tax-policy/tax-database

www.1212.mn

www.mains.mn

www.iltod.gov.mn

www.worldwide-tax.com

www.home.kpmg/it/it/home/services/tax/tax-tools-and-resources/tax-rates-online/indirect-tax-rates-table.html